ВИДЕО ШТОРК · 2024 оны 2-р сарын 5

2023 ОНД АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН 329 ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЭВ



Прокурорын байгууллага 2023 онд авлига, албан тушаалын 1661 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан бөгөөд 2022 онтой харьцуулбал 20 хувиар өсжээ.

Үүнээс 256 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн бол энэ төрлийн 329 хэргийн шүүх хуралдаанд прокурор улсын яллагчаар оролцож, шийдвэрлүүлсэн байна. Тодруулбал,

- Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 203 хэрэгт 177 хүн,

- Хахууль авах 61 хэрэгт 94 хүн,

- Хахууль өгөх 65 хэрэгт 160 хүн, 2 хуулийн этгээдэд холбогдох хэргийг шүүхээр хэлэлцүүлж, эрүүгийн хариуцлага оногдуулжээ.

Мөн авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болох 8.9 тэрбум төгрөг, 5.000 рубль, 547 мянган евро, 65 мянган ам.доллар, 6 хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг гэм буруутай этгээдээс хураан авч, улсын орлого болгуулсан байна.

2023 онд бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 65 хувь нь Нийслэлд, 35 хувь нь орон

нутагт, үүнээс Сэлэнгэ, Баян-Өлгий аймагт хамгийн их бүртгэгдсэн. Нийт бүртгэгдсэн хэргийн 77 хувийг улс төрд нөлөө бүхий болон нийтийн албан тушаалтан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулсан гэмт хэрэг эзэлж байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=srbZi9RYpXI

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1443